

ТЕЛЕВИЗИЙН БҮТЭЭЛИЙН ФОРМАТ: ШИНЭ ХАНДЛАГА, ХОЛИМОГ ХУВИЛБАРУУД

Т.Өнөрсайхан*

*МУИС, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: вэб баримтат бүтээл, баримтат жүжиг, баримтат савангийн дуурь, баримтат шог, ток шоу, реалити шоу, синдикат

“Үзэгчид зурагтын өмнө суухдаа юу хүсэж байгаагаа мэддэггүй, суваг сольж тухайн үед анхаарал татсан нэвтрүүлгүүдийг сонгон үздэг. Тиймээс тэдний хүслийг урьдчилан таамаглаж, сонирхлыг нь татах бүтээл хийх ёстой. Үүний тулд зорилтот бүлгээ судлах, тэдний онцлогийг ойлгож, мэдэх шаардлагатай.” гэж Америкийн судлаач Ийстман С.Т, Фергусон Д.А нар “Мэдээллийн хэрэгслийн хөтөлбөр төлөвлөлт: стратеги ба арга зүй” номондоо дурджээ. (Eastman S.T & Ferguson D.A, 2012) Үнэндээ үзэгчдэд ямар төрөл зүйл, форматын бүтээл байх нь ач холбогдолгүй байдаг. Тухайн цаг мөчид анхаарлыг нь татах үйл явдал, эсвэл таалагддаг сэдвүүдийг нь хөндөхөд сонгож үздэг байна. Харин дам байдлаар бол тэднийг сонголтоо хийхэд формат, төрөл зүйл онцгой үүрэг гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, үзэгч анхнаасаа ток шоу үзье гэж зорьж үздэггүй. Эхэлж сэдвийг нь сонгодог ч тухайн бүтээлийн агуулгыг хөгжүүлж,

сонирхолтой болгон сонголт хийхэд формат чухал нөлөө үзүүлдэг байна.

Телевизийн төрөл зүйл, форматын үр нөлөөний талаар хэсэг судлаачид дараах судалгааг хийсэн байна. Тэд тодорхой нэг сэдвийн хүрээнд телевизийн ярилцлагын форматын гурван хувилбарыг сонгон авч тус бүрд нь нэвтрүүлэг бэлджээ. Хөтлөгч-оролцогчийн харилцан ярилцах ярилцлага, мэтгэлцээн, ток шоу хийсэн байна. Форматын хувьд оролцогчдын тоог бага, дунд, том гэсэн бүлгээр зохион байгуулж, харилцааны урсгалыг хөтлөгч оролцогч гэсэн нэг чиглэлт байдлаас хөтлөгч оролцогчид гэж олон талт болгон, нэгжээс ерөнхийгийн хэлбэрт шилжүүлжээ. Бүлгийн үзэлтүүдийг хийсний дараа эхний буюу нэг урсгалт ярилцлагыг оролцогчид дүгнэхдээ “уйтгартай, нэг хэвийн, онц биш, үзэхээр биш сонсоход хангалттай байсан” гэсэн бол мэтгэлцээнийг “хэт албаны, үр дүн тодорхойгүй, зохион байгуулалттай” гэжээ. Харин гурав дахь ток шоууг “олон хүний байр суурь оролцсон учраас гэнэтийн санаа ихтэй, үйл явдал хаашаа ч эргэж болохоор сонирхолтой, энгийн илүү ойлгомжтой” байсан гэж хариулсан байна. (Кузнецова.В.С, 2010) Өөрөөр хэлбэл, 30 минутын турш хоёр

хүн урд урдаасаа хараад яриад суухаас илүү үндсэн зургаан талт оролцооны байр суурийг илэрхийлдэг ток шоу үзэгчдийн анхаарлыг илүү татсан байна. Яг нэг сэдвээр хийсэн боловч хүртээмж, нөлөөллийн хүрээ, оролцогчдын тоо нэмэгдэх, хөдөлгөөнт дүрс олшрох, гэнэтийн үйл явдлын өөрчлөлт зэрэг ток шоуны формат нь үзэгчдийн сонирхлыг илүү татжээ.

Телевизийн бүтээл дүрсийг харах, сонсох, уншиж ойлгох гэсэн олон талт онцлогт тулгуурлан байнгын хөдөлгөөнд оршиж, агуулгаар төдийгүй хийц, дүрсэн өгүүлэмжээр үзэгчдийн анхаарлыг татдаг үндсэн мөн чанартай. Дээрх судалгаанаас дүгнэхэд телевиз өөрийн дахин давтагдашгүй шинж чанараа хадгалж үлдэхийн тулд бүтээлийн төрөл бүрийн өвөрмөц шинэ форматуудыг байнга нэвтрүүлэх шаардлагатай ажээ.

Олон улсын телевизийн зах зээлд тэргүүлж буй синдикат бүтээлийн сонголтыг ток шоу, реалити шоу, варьете шоу тэргүүлсээр байна. Мэдээллийн хөтөлбөр, сериал, ситком, спортын нэвтрүүлгүүдийн үзэлт цаг үе, онцгой нөхцөл байдлыг эс тооцвол хүчтэй хэлбэлзэлгүй тогтсон үзүүлэлттэй байна. Интернэт даяаршлын явцыг хурдасгаж бүтээл үйлдвэрлэгчид соёлын эрс ялгаатай байдлыг харуулах гэхээсээ илүүтэй хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлд тулгуурласан, тухайн цаг үеийн амьдралын ерөнхий хэв шинжийг хадгалсан сэдэв, хэлбэрийг илүүтэй сонгох болсон. Реалити телевизийн хэлбэр, варьете шоуууд энэ тохиолдолд хамгийн тохиромжтой хувилбар болж байгаа юм.

Форматын хувьд бүтээлүүдийг бүлэглэн авч үзвэл уламжлалт болон

шинэ форматын бүтээлүүд зэрэгцэн гарч иржээ. Уламжлалт ангилалд ток шоу, уралдаант цэнгээнт бүтээлүүд, варьете шоу, реалити шоу, “савангийн дуурь” буюу сериалууд, мэдээллийн хөтөлбөр, спортын нэвтрүүлгүүд байна. Харин хүлээн авагчдын анхаарлыг татсан сонголттой шинэ форматын тоонд анимэ, докудрам, вэбдок буюу вэб баримтат бүтээл орж байна. Энэ нь мэдээллийн технологийн нөлөө төрөл бүрийн мультимедиа хувилбарыг телевизийн бүтээлд ашиглах боломжийг бий болгож, нөгөө талаар реалити буюу бодит байдлыг зөвхөн шоу цэнгээн хэлбэрээр биш баримтат жүжиг, шог байдлаар харуулах болсон гэсэн үг юм.

Иймд зохиогч тус өгүүллээрээ телевизийн бүтээл үйлдвэрлэлд сүүлийн үед түлхүү ашиглах болсон холимог форматуудыг задалж тайлбарлан, тэднээр дамжин илрэх стратегийн талаар судалж, нэгтгэн дүгнэн бичсэн болно. Ингэхдээ онолын судалгаа хийж түүхчилсэн, харьцуулсан, мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглалаа.

Телевиз нийгмийн амьдралын тусгал юм. Бодит амьдралыг дэлгэцэд буулгаж, тухайн үеийн нийгмийн давамгайлалч өнгө төрхийг харуулдаг. Үзэгчдийн сонирхлыг татаж буй форматуудын нийтлэг хэлбэр нь документал буюу баримтат гэсэн нэгдсэн утга юм. Энэ нь телевизийн сэтгүүл зүйн үүрэг, зарчмыг цөм болгон агуулж буй хосолмол хийц бүхий бүтээл гэдгийг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, бодит үйл явдлын баримтад тулгуурлаж технологи, дүрслэлийн бусад хэлбэрийг ашигласан хувилбар юм.

ВВС телевизээр 1969 оноос “Монти-Пайтоны нисдэг цирк” цэнгээнт

нэвтрүүлэг гарах болсон байна. Скетч-шоу хувилбар бүхий тус нэвтрүүлэг тухайн үедээ үзэлт өндөр байсан нь ярилцлага, дуу хөгжим, үзүүлбэр зэрэг илэрхийллийн олон талт байдлаас гадна агуулгын хувьд нийгмийн тулгамдсан асуудлыг шог шүүмжлэлт өнгө аясаар илэрхийлж байсантай нь холбоотой юм. Тиймээс хожим нь “Монти пайтон” гэсэн нэр нь инфотейнмент хөтөлбөрийн нэг чиглэл болон үлдсэн билээ. Инфотейнмент хөтөлбөрийн “Монти пайтон” хэлбэрийн мөн чанар нь тодорхой дүрийг бүтээж, тус дүрээр дамжуулан нийгмийн асуудлыг шоглон үзүүлэх байдаг. Ингэхдээ анхны хувилбаруудад зурмал, чихмэл хүүхэлдэйн баатрын хувцастай дүрүүдийг бүтээж нийгмийн тодорхой сэдвийг шоглон мэдээлдэг байв. Яваандаа дүрийнхээ дүр төрхийг улам тодорхой болгож улс төрчдийн хошин дүр бүхий багтай хүмүүс, зурмал дүрүүд нь өөрсдийн тухай ярих, инфотейнмент мэдээ унших, эсвэл зураачид нэвтрүүлгийн үеэр үйл явдлын зураг зурж, шог байдлаар асуудлыг тайлбарлах зэрэг төрөл бүрийн хувилбарыг ашиглаж байв. “Монти пайтон” бол вэбдок буюу вэб документаривэб баримтат бүтээлийн анхдагч хэв шинжийн нэг юм.

2002 онд Парис хотноо болсон Олон улсын баримтат киноны “Cinema du Reel” наадмын үеэр вэб баримтат бүтээл гэсэн үгийг анх хэрэглэжээ. Уламжлалт баримтат нэвтрүүлэг болон мультимедиагийн завсрын бүтээл юм.

Мультимедиа бүтээлд хэрэглэгддэг гэрэл зураг, эх бичвэр, дуу, дүрс, анимейшн, инфографикийг бүгдийг ашигладаг боловч үндсэн цөм нь дүрс буюу видео байдгаараа онцлогтой. Тодруулбал,

уламжлалт нэвтрүүлгүүд шиг зураг авалтыг хийж харин технологид суурилсан бусад хэрэглэгдэхүүн буюу гэрэл зураг, эх бичвэр, дуу, анимейшн, инфографикийг тухайн бүтээлийг баяжуулах, өгөгдлийн хувьд сонирхолтой байлгах зорилгоор нэмэлтээр ашиглана. Телевизийн уламжлалт нэвтрүүлгийн технологи буюу дүрсэн өгүүлэмж дээр суурилдаг учраас мультимедиа бүтээлээс ялгаатай юм. Нөгөө талаар мультимедиад зохиолын шууд шугаман хэлбэрийг ашигладаг. Харин вэб баримтат бүтээлд орсон нэгжүүдийг салган авч үзвэл тус бүрдээ бие даасан утга илэрхийлэх боломжтой, уламжлалт нэвтрүүлгүүдийн зохиол дахь төрөл бүрийн эргэлт, тааварлашгүй нөхцөл байдал, үр дүнг ашигладаг байна.

Нягтрал өндөртэй хөдөлгөөнт дүрс, тоон код, интернэт платформоор бүтээлээ хуваалцах гэсэн үндсэн гурван шинж чанар вэб баримтат бүтээлийг тодорхойлох бас нэг онцлог болдог. Эхэн үедээ зөвхөн мультимедиа шиг интернэт платформ дээр хөгжүүлж, интернэт телевизийн үндсэн бүтээл болно гэж үзэж байсан ч сүүлийн үед өргөн нэвтрүүлэгт зориулж хийж, цацах болжээ.

Баримтат кинонд анх өргөнөөр ашиглаж байсан ч яваандаа телевизийн нэвтрүүлэг болон орж ирсэн докудрам буюу баримтат “жүжиг” нь документар хэлбэрийн бүтээлүүдийн хамгийн түгээмэл формат юм. Гэхдээ нэр томъёоны хувьд олны дунд илүү танигдсан болохоос баримтат жүжгээс дутахгүй баримтат “савангийн дуурь”, баримтат “шог” гэсэн форматууд мөн ашиглагддаг.

Баримтат жүжгийн форматыг эхэн үедээ зөвхөн баримтат кинонд ашигладаг байв. Яваандаа телевизийн

нэвтрүүлэгт өргөн хэрэглэх болж, сүүлийн үед эдютейнмент, сургалтын бүтээлүүдэд ашиглах нь үр дүнтэй арга гэж үзэх болжээ. Баримтат жүжгийн анхны үүсэл санааг эртний уран зохиол, библийн түүхэн зургууд, Аристотелийн уран зургийн онолтой холбон тайлбарладаг. Яг хаана баримтат жүжгийн форматаар хийсэн бүтээл анх гарсан бэ гэдэг талаар олон янзын баримт бий. Дэлхийн хоёрдугаар дайны үед баримтат мэдээ, сурвалжилга хүчээ авч байх үед үзэгчдэд итгэл үнэмшил төрүүлэх үүднээс энэ аргыг хэсэгчлэн ашигладаг байсан байна. Албан ёсоор дайны дараа “ХХ зуун фокс” кино компани баримтат жүжгийн форматаар гэмт хэргийн цувралуудыг бүтээх болжээ. Хамгийн алдартай нь Лос-Анжелес хотын цагдаагийн газрын мөрдөгчдийн гэмт хэрэг хэрхэн мөшгиж буй тухай “Dagnet” цуврал юм.

Би-Би-Си телевиз 1960-аад оны үеэс баримтат жүжгийн цуврал хийх болсон байна. Энэ төрлийн телевизийн бүтээлийг форматын хувьд хэв шинжээ олоход Питер Уоткинс чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Би-Би-Си-ийн сэтгүүлчдийн ярилцлага хэлбэрээр баримтат жүжгийн бүтээлээ хийж байжээ. Мөн Кен Лоучийн орон гэргүй тэнүүчлэн амьдардаг иргэдийн нийгмийн асуудлыг хөндсөн “Кети гэртээ ирээч!” баримтат жүжиг энэ форматын онцлогийг бүрэн дүүрэн гаргаж чадсан анхны хувилбаруудын нэг гэж тооцогд-

дог юм. Ямар нэгэн таагүй нөхцөлд байгаа хүн асуудлаа ярихыг хүсдэггүй, тухайн нөхцөл байдлыг илэрхийлэхэд нэг удаагийн зураг авалт хангалтгүй, гэнэтийн болж өнгөрсөн зүйлийг үзүүлэх дүрс дутах, эсвэл бүр зураг авахыг хориглосон байх зэрэг олон шалтгаан үйл явдлыг дахин сэргээхэд нөлөөлсөн гэж Кен Лоуч бүтээлийнхээ талаар хожим ярьсан байдаг. (Шергова.К.А, 2011)

Докудрам буюу баримтат жүжгийн онцлог нь нэгэнт болж өнгөрсөн явдлыг дахин дүрслэн сэргээж, түүнийг мэргэжлийн хүмүүс “тоглол” харуулдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, түүхэн эсвэл болж өнгөрсөн ямар нэгэн үйл явдлыг өнөө цагтай уялдуулан үнэлэлт дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, олонд таниулах зорилгыг агуулдаг. “Жүжиг” буюу драма гэсэн үгээр давхар илэрхийлэгддэг учраас

зарим тохиолдолд хуурамчаар бүтээх, жүжиглэх гэсэн утга агуулагдаж байна гэж хардах хүмүүс байдаг. Гэтэл баримтат жүжгийн мөн чанар нь баримттай болсон үйл явдлыг түүхэн архив, тэмдэглэл, гэрчийн мэдээлэл дээр үндэслэн дахин сэргээж байгаа асуудал болохоос тэнд жүжиглэлт, тоглолт, жүжигчний ур чадварын асуудал огт яригддаггүй. Цэвэр сэтгүүл зүйн бүтээлийн баримтыг илэрхийлэх дүрслэлийн аргаар гаргаж ирдэг онцлогтой юм. Баримтат киноноос телевизийн өдөр тутмын

«

Докудрам буюу баримтат жүжгийн онцлог нь нэгэнт болж өнгөрсөн явдлыг дахин дүрслэн сэргээж, түүнийг мэргэжлийн хүмүүс “тоглол” харуулдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, түүхэн эсвэл болж өнгөрсөн ямар нэгэн үйл явдлыг өнөө цагтай уялдуулан үнэлэлт дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, олонд таниулах зорилгыг агуулдаг

»

нэвтрүүлгийн форматад шингэж яваандаа бие даасан хэлбэр болсон баримтат жүжиг 1970-аад оноос өмнөх үед ихэнхдээ дүрсний дутагдалтай талыг нөхөх зорилгоор илүүтэй ашиглагдаж байсан бол 1980-аад он гэхэд үйл явдлыг илүү нарийн ойлгуулах, таниулах зорилгоор буюу агуулгын түвшинд хэрэглэгдэх болжээ.

Телевизийн бүтээлийн холимог хувилбарууд буюу инфотейнмент, эдютейнментүүд хүчээ авснаар баримтат жүжгийн шинэ үе эхэлсэн байна. Сургалт, танин мэдэхүйн чиглэлийн бүтээлд тус форматыг түлхүү ашиглах болжээ. Манайд энэ төрлийн бүтээлүүд ховор хийгдсэн байдаг. Зардал, байнгын эрэл хайгуул, нарийн ажиллагаа зэрэг олон талт байдал ийм төрлийн бүтээлийн үйлдвэрлэлд шууд нөлөөлдөг юм. Харин 2000-аад оны дундуур “25 дугаар суваг” телевиз “Дуулиант хэрэг” цувралуудыг бүтээсэн нь Монголын телевизийн салбарт хийгдсэн баримтат жүжгийн бодит жишээ юм.

Холимог бүтээлийн төрлүүдээс хамгийн түгээмэл нь докудрам буюу баримтат жүжиг боловч энэ нэрийн дор документар бүтээлийн зарим форматыг нэгтгэн ойлгох нь бий. Үзэлтээрээ тэргүүлэгч докудрам гэсэн нэрийн дор баримтат “савангийн дуурь” (docu-soap – documentary soap), баримтат “шог” (mockumentary)-ийг нэгтгэж үзээд байдаг. Гэтэл эдгээр нь тус бүрийн концепц, агуулга зохион байгуулалт бүхий бие даасан холимог форматууд юм.

Docusoap буюу Баримтат “савангийн дуурь” (Зулькафиль.М, 2011) нь бодит хүмүүс, үйл явдал, тэдний амьдралыг ээдрээ, зөрчилтэйгөөр цувралаар гаргаж буй олон ангит

цуврал юм. Баримтат жүжиг ихэвчлэн өнгөрсөн цаг дээр бүтээгдэж, тэр хэрээрээ түүхэн үйл явдлыг эргэн сануулдаг, үйл явдал, нийгмийн асуудал төвтэй байдаг бол баримтат “савангийн дуурь” хүн төвтэй бүтээгддэгээрээ онцлогтой юм. Тэр утгаараа реалити шоутай андуурах нь бий. Гэтэл реалити шоу бол концепцын хувьд “gamification” буюу бодит байдал болон телевизийн болзолт үйлдлийн харилцан үйлчлэлийн хүрээгээр тодорхойлдог урьдчилсан төлөвлөгөөт, зохиомж бүхий харилцааг бодит байдлын дүр зураг мэтээр харуулдаг телекоммуникацийн нэг хэлбэр юм.

Харин баримтат “савангийн дуурь” бол баримтат жүжигтэй харьцуулахад одоо цагийн илэрхийллээр хийгддэг, реалити шоутай харьцуулахад заавал урьдчилсан тоглолт, зохиол гэхээсээ болсон үйл явдлынхаа агуулгад тулгуурлаж хийгддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, баримтат “савангийн дуурь”-ийг бүтээлийн зураг авалтын явц болон эвлүүлгийн үед хийж болдог байна. Баримтат “савангийн дуурь” гэсэн үндсэн концепыг илэрхийлдэг гол хүчин зүйл нь сэдэв юм. Хүн хоорондын харилцааны зөрчил, хайр дурлал, мэдрэмж, уян зөөлөн байдал гэсэн сэдвүүд үндсэн зангилаа болж бодит дүрүүдийн харилцааг цуврал хэлбэрээр үзүүлдэг. “ХХ зууны амрагийн алдартай түүхүүд” цуврал баримтат “савангийн дуурь”-ийн нэг жишээ юм. Үйл хэргээрээ олонд танигдсан хүмүүсийн хувийн амьдрал, хайр сэтгэлийн харилцааг тус цувралаар өгүүлсэн байдаг. Манайд баримтат “савангийн дуурь” хэлбэрээр хийгдсэн бүтээл одоогоор байхгүй байна.

Баримтат жүжиг нь түүхэн, өнгөрсөн үйл явдлыг илэрхийлэх онцлогтой бол баримтат “савангийн дуурь” нь хүн хоорондын харилцаа, мэдрэмж, сэтгэлийг гаргахыг зорьдог. Документари буюу баримтат форматын бас нэг түгээмэл чиглэл болох мөкюментари (mockumentary) нь баримтат шог буюу дэлгэцийн “фельетон”-ы нэг хувилбар гэж тооцогддог. 1957 онд Их Британийн “Панорама” нэвтрүүлгээр “Цвейцарийн гоймонгийн ургац” нэртэй мэдээ явжээ. Дөрөвдүгээр сарын нэгний шоглоом хэлбэрээр цацсан энэ мэдээлэлд хүмүүс итгэж, яг хаана ургадаг, ямар төрлийн мод гэх зэргээр асууж байжээ. Хожим энэ мэдээллийг хуурамч мэдээлэлд хүмүүс хэрхэн итгэдэг талаарх жишээ болгон баримтат шог бүтээлд ашигласан байдаг.

Баримтат жүжгийн бүтээлээр олонд танигдсан Питер Уоткинс баримтат шог бүтээлийн хэлбэрээр 1965 онд “The war game”, 1971 онд “Punishment Park” бүтээлүүдээ хийсэн байна. Вьетнамд хийж байгаа Америкийн дайнтай холбоотойгоор улс төрийн гадаад болон дотоод бодлогын асуудлыг хөнджээ. Тухайн үедээ баримтат шог гэхээсээ илүүтэй баримтат жүжгийн формат гэж тайлбарлаж байв. 1980-аад оны дундуур Роб Райнерын “This is Spinal Tap” бүтээл гарч мөкюментари гэсэн нэр томъёо албан ёсоор бий болсон гэж үздэг.

Реалити телевизийн нэг чиглэл болж хөгжсөн документари төрлийн форматыг баримтат жүжиг буюу докюдрамаар голчлон төлөөлүүлэн үздэг нь бие биедээ ууссан ижил төстэй хийцтэй нь холбоотой. Тухайлбал, зарим баримтат шог бүтээл нь өнгөрсөн түүхийн зарим асуудлыг хөндөж баримтат жүжгийн хэлбэрээр

хийгдсэн боловч элэглэл, шогийн өнгө аясыг агуулсан “дэлгэцийн фельетон” хэв шинжээрээ мөкюментари болж байна. Манайд баримтат шог, элэглэлийн энэ хэлбэрийн зарим хэв шинжийг “361 градус” хөтөлбөрөөр гаргаж байв. Гэхдээ бүрэн утгаар нь форматыг илэрхийлж байсан гэж үзэх боломжгүй юм.

Телевиз олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болохын хувьд бусдаасаа ялгарах өөрийн өвөрмөц давтагдашгүй хэв шинжийг агуулдаг. Гэхдээ хүлээн авагчдын зан төлөвт өөрчлөлт орж телевиз үзэгчдийн тоо, үзэлтийн хугацаа дэлхий нийтээр бууралттай гарах болсонтой маргах аргагүй юм. Ийм тохиолдолд үзэгчдийг татах, нөгөө талаар ижил төрлийн видео үйлдвэрлэж буй нийгмийн сүлжээ, интернэт орчны бүтээлүүдээс төрөл зүйл, форматын онцлог, оролцооны хамрах цар хүрээгээрээ ялгаран гарах нь өрсөлдөөнд тэсэж үлдэх нэг гарц гаргалгаа билээ. Ямар ч төрлийн видео бүтээлийг хүссэн сувгаараа үзэх боломжтой болсон нь телевизийн бүтээлийг илүү мэргэжлийн, ур чадвартай хийхийг шаарддаг болгосон. Синдикат бүтээлийн хамгийн үзэлттэй формат болох ток шоу, реалити шоу, ситком, мэдээллийн хөтөлбөрүүд, документари форматууд нь энэ хэрэгцээ шаардлагын дагуу хийгдэж, телевизийн өвөрмөц хэв маягаа хадгалж чадсан учраас үзэлтийн тавцанд байсаар байна. Олон ангит кино, мэдээллийн хөтөлбөр, студийн ярилцлага, теле худалдаа гэсэн цөөн нэвтрүүлэгт оргил цагийн ихэнх хугацаагаа зарцуулдаг манай телевизүүдийн тухайд нэгэнт олон улсад эрэлттэй болсон дээрх холимог форматуудыг ашиглах нь телевизийн төдийгүй бүтээлийнхээ

өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нэг арга зам мөн юм.

Эшлэл

1. Eastman S.T, Ferguson D.A. 2012. Media programming: strategies and practices. Cengage learning., p.10.
2. Кузнецова В.С. 2010. Жанровые медиатрансформации. РНД.
3. Шергова К.А. 2011. Докудрама-новый жанр. Мос.
4. Зулькафиль М. 2011. Сэтгүүл зүй тайлбар толь. УБ. х 209.
7. Eurodata TV worldwide. 2019. Global audience and content evolution. L.
8. James Roman 1998. Love, light and a Dream: Television past, present and future.
9. Hill A. 2005. Reality TV: Audiences and popular factual television. L.
10. Museum of Broadcast communications. 2013. Encyclopedia of television. NY.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2011. Сэтгүүл зүй тайлбар толь. УБ.
2. Мэндхүү Г, Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
3. Гегелова Н.С. 1997. Жанры телевизионной журналистики. М.
4. Кузнецова В.С. 2010. Жанровые медиатрансформации. Р.
5. Шергова К.А. 2011. Докудрама-новый жанр. Мос.
6. Eastman S.T, Ferguson D.A. 2012. Media programming: strategies and practices. Cengage learning.

Summary

This paper presents a case study of specific developments in the format on television. Based on the multifaceted features of watching, listening, reading television contents are in constant motion and abstract the audience's attention not only topics, but also by design and formation. As can be concluded from the above research, in order for television to maintain its unique characteristics it is necessary to constantly introduce new unique formats of work.

Keywords: web documentaries, docudramas, docu-soaps, docu-comics, talk shows, reality shows, syndicate.